



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Булган сумын “Коксаг” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/044/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өмнөговь аймаг  
2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас:70533539 Цахим хаяг:usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Г.Шижирболд  
Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК Захирал:  
Г.Энхмаа  
Утас: 77450279 99040059 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b>	<b>4</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b>	<b>7</b>
3.1 Төлбөрийн акт	8
3.2 Албан шаардлага	8
3.3 Зөвлөмж	8
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b>	<b>9</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНТХ	Орон нутгийн төсвийн хөрөнгө

---

# 1. ХАРААТ БУС АУИТОРЫН ДҮГНЭЛТ



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 316

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН  
СУМЫН КОКС ЗАГ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Н.ОТГОНБААТАР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь аймгийн Булган сумын "Коксзаг" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 743.4 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 348.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 8.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өмнөх онд хүлээн авсан хөрөнгөтэй холбоотой 4,815.3 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

### Бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн

4626050492

Бичиг хэрэг 2025 он ЦТА-н дүгнэлт Тасал Дорж

тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	218,024,412.31	176,535,710.68
2	Татвар, НДШ-ийн авлага	1,611,414.76	1,635,435.41
3	Бусад авлага	4,940,937.76	-
4	Бараа материал	27,718,730.73	43,957,440.83
<b>5</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>252,295,495.56</b>	<b>222,128,586.92</b>
6	Үндсэн хөрөнгө	5,217,040,739.93	5,004,432,251.88
7	Биет бус хөрөнгө	10,782,000.00	10,782,000.00
<b>8</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>5,227,822,739.93</b>	<b>5,015,214,251.88</b>
<b>9</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,480,118,235.49</b>	<b>5,237,342,838.80</b>
10	Татварын өр	1,977,175.15	-
<b>11</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,977,175.15</b>	<b>-</b>
12	Хойшлогдсон татварын өр /ОНХОруулалт/	5,063,065,644.61	4,815,297,289.53
<b>13</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,063,065,644.61</b>	<b>4,815,297,289.53</b>
<b>14</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>5,065,042,819.76</b>	<b>4,815,297,289.53</b>
15	Өмч: - төрийн	138,546,729.00	138,546,729.00
16	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	32,496,695.83	32,496,695.83
17	Эздийн өмчийн бусад хэсэг	62,165,333.85	62,165,333.85
18	Хуримтлагдсан ашиг	181,866,657.05	188,836,790.59
19	Тайлангийн үеийн ашиг	-	6,970,133.54
20	Өмнөх үеийн ашиг	181,866,657.05	181,866,657.05
21	Эздийн өмчийн дүн	415,075,415.73	422,045,549.27
<b>22</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,480,118,235.49</b>	<b>5,237,342,838.80</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого(цэвэр)	638,744,769.68	743,442,691.59
2	Борлуулалтын өртөг	606,900,687.41	920,163,990.80
3	Нийт ашиг( алдагдал)	31,844,082.27	-176,721,299.21
4	Бусад орлого	180,383,618.39	348,238,161.08
5	Орлогын дүн	819,128,388.07	1,091,680,852.67
6	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
7	Ерөнхий ба удирдлагын зардал	107,609,391.66	163,050,342.33
8	Зардлын дүн	714,510,079.07	1,083,214,333.13
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	4,158,883.05	0.00
11	Олз, гарзын дүн	0.00	649,734.14
12	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	100,459,425.95	8,466,519.64
13	Орлогын татварын зардал	10,461,83.90	846,651.96
14	Хойшлогдсон татварын зардал	0.00	0.00
15	Татварын дараах ашиг( алдагдал)	89,997,597.05	7,619,867.68
16	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
17	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	89,997,597.05	6,970,133.54

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	200,712,062.85	32,496,695.83	0.00	181,866,657.05	<b>415,075,415.73</b>
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	6,970,133.54	<b>6,970,133.54</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	<b>0.00</b>
<b>2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	<b>200,712,062.85</b>	<b>32,496,695.83</b>	<b>0.00</b>	<b>6,970,133.54</b>	<b>422,045,549.27</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
2	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3	Мөнгөн орлогын дүн (+)	731,011,048.97	920,770,265.50
4	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	731,011,048.97	903,463,822.50
5	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	17,633.00
6	Бусад мөнгөн орлого	0.00	17,288,810.00
7	Мөнгөн зарлагын дүн (-)	612,809,062.14	953,864,603.50
8	Ажиллагчдад төлсөн	235,687,605.30	390,724,662.00
9	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	66,469,636.60	115,895,691.17
10	Бараа материал худалдан авахад төлсөн	86,915,440.00	89,075,550.00
11	Ашиглалтын зардалд төлсөн	27,009,855.91	44,826,384.79
12	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	104,966,705.00	146,347,807.00
13	Татварын байгууллагад төлсөн	80,818,249.33	94,198,313.54
14	Бусад мөнгөн зарлага	10,941,570.00	72,796,195.00
15	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	118,201,986.83	-33,094,338.00
16	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
17	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
18	Мөнгөн зарлагын дүн (-)	2,668,999.82	8,394,363.63
19	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,668,999.82	8,394,363.63
20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,668,999.82	-8,394,363.63
21	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
22	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
23	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
24	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
25	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	115,532,987.01	-41,488,701.63
26	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	102,491,425.30	218,024,412.31
27	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	218,024,412.31	176,535,710.68

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		ЗӨРҮҮ
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>Нийт орлого</b>		<b>сая төг</b>	<b>819.1</b>	<b>1,062.7</b>	<b>1,091.7</b>	<b>29.7</b>
Үүнээс:	<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>сая төг</b>	<b>543.8</b>	<b>556.3</b>	<b>570.8</b>	<b>14.5</b>
	ДЭХ-ний орлого	сая төг	512.4	526.3	530.4	4.1
	Цэв- бохир ус	сая төг	31.4	30.0	40.4	10.4
	Орон нутгийн төсвийн санхүүжилт	сая төг	30.1	87.3	79.6	(7.7)
Үйл ажиллагааны бус орлого		сая төг	245.2	419.1	441.3	22.2
<b>Нийт зардал</b>		<b>сая төг</b>	<b>718.7</b>	<b>1,061.8</b>	<b>1,083.9</b>	<b>22.1</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>		<b>сая төг</b>	<b>714.5</b>	<b>1,061.8</b>	<b>1,083.2</b>	<b>21.4</b>
Үүнээс	Тээвэр, шатахуун	сая төг	94.8	128.0	109.7	(18.3)
	элэгдэл	сая төг	167.7	284.0	286.2	2.2
	бусад тогтмол	сая төг	452.0	649.8	687.3	37.5
Үйл ажиллагааны бус зардал		сая төг	4.2	-	0.7	0.7
Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг	100.4	0.9	7.8	6.9
<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>		<b>сая төг</b>	<b>89.9</b>	<b>0.8</b>	<b>7.0</b>	<b>6.2</b>
Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		Төг	0.87	1.0	0.99	0.01
<b>Нийт авлага</b>		<b>сая төг</b>	<b>6.6</b>	<b>0.0</b>	<b>1.6</b>	<b>(5.0)</b>
Үүнээс:	ЭХ-ний	сая төг	-	-	-	-
	Бусад /НА хасагдсан/	сая төг	6.6	-	1.6	(5.0)
<b>Нийт өглөг</b>		<b>сая төг</b>	<b>5,065.0</b>	<b>-</b>	<b>4,815.3</b>	<b>(249.7)</b>
Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая төг	2.0	-	-	(2.0)
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	5,063.0	-	4,815.3	(247.7)
Нийт ажиллагсад		тоо	17	21	21	-
<b>Нийт цалингийн сан</b>		<b>сая төг</b>	<b>231.8</b>	<b>388.8</b>	<b>374.2</b>	<b>(14.6)</b>
<b>Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт</b>		<b>сая төг</b>	<b>2,7</b>	<b>55.2</b>	<b>53.0</b>	<b>(2.2)</b>

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

### 3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:  
1. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт1:** Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хамааралгүй гүйлгээг бичиж өртгийн дүнг нэмэгдүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”; Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар”-ыг

зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

**Өгсөн зөвлөмж:** Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хамаарах зардлыг үнэн зөв ангилж бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хамааралгүй гүйлгээг бичиж өртгийн дүнг нэмэгдүүлсэн байна.	1	3.2					1	3.2
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>3.2</b>					<b>1</b>	<b>3.2</b>